



**БАРАА ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

<b>Тендер шалгаруулалтын нэр</b>	<b>“Шивээ овоо” ХК-д 3.2м3 дээш шанагатай гидроэкскаватораар ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгох сонгон шалгаруулалт</b>
<b>Тендер шалгаруулалтын дугаар</b>	<b>ШО/201906001</b>
<b>Огноо</b>	<b>2019.06.24</b>

---

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2019.06.24**

Тендер шалгаруулалтын нэр:

**3.2м3 дээш шанагатай гидроэкскаватораар ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгох сонгон шалгаруулалт**

Тендер шалгаруулалтын дугаар: **[ШО/201906001]**

**[“Шивээ Овоо” ХК ]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[3.2м3 дээш шанагатай гидроэкскаватораар ажил гүйцэтгэх]**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татан авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **[ 2019 оны 7-р сарын 1 ]** өдрийн **[ 9 цаг 30 минут ]** --аас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[ 2019 оны 7-р сарын 1 ]**-ны өдрийн **[ 10 цаг ]**-аас **[ Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, “Шивээ Овоо” ХК, Худалдаа хангамжийн албаны өрөө]**<sup>1</sup>-д нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг, бусад мэдээллийг [tender.gov.mn](http://tender.gov.mn), [shivee-ovoo.mn](http://shivee-ovoo.mn) сайтаас болон доорх утсаар лавлаж болно.

**[ Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, “Шивээ Овоо” ХК, Худалдаа хангамжийн алба ]**

**[ Утас: 88886339, 99029879, 99903261 ]**

---

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

---

## Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТООЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Компаний танилцуулага</li> <li>2. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>3. Шүүхийн төрөлжсөн архивын газрын тодорхойлолт</li> <li>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>5. Сүүлийн [ <b>2018 он</b> ] аудитлагдсан санхүүгийн тайлан</li> <li>6. Сүүлийн [ <b>2018 он</b> ] туршлагын мэдээлэл</li> <li>7. Гэрээний үнэ, хугацаанд техникийн шаардлага хангасан барааг хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл</li> <li>8. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлсэн тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан мэдэгдэл</li> <li>9. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон хугацаанд барааг нийлүүлээгүй тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан мэдэгдэл</li> </ol>
ТООЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн аж ахуй нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч тендерийн материалыг цахим хэлбэр /PDF/-ээр ирүүлнэ.</p> <p>Огноо: <i>[2019 оны 7 дугаар сарын 1-ны өдөр]</i></p> <p>Цаг: <i>[ 9 цаг 30 минут ]</i></p>
ТООЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>[ Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг, өөрийн оффисе, ХХАлбаны өрөө ]</i></p> <p>Огноо: <i>[2019 оны 7 дугаар сарын 1-ны өдөр]</i></p> <p>Цаг: <i>[ 10 цаг ]</i></p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

1	Захиалагч	“Шивээ Овоо” ХК
2	Байршил /чиглэл/	Говьсүмбэр аймаг, Шивээговь сум
3	Нөхцөл	Түрээсээр ажиллуулах
4	Хугацаа	1 сар
5	Хүчин чадал	Шанаганы багтаамж 3.2 м3-ээс багагүй
6	Ажиллах цаг /хоногт/	Ээлжийн бүтээлтэй цаг /9.5/ байх ба ээлж хүлээлцэлт, бэлтгэл төгсгөл, цай хоол, тосолгоо үйлчилгээ /2.5/ нийт 12 цагаар хоногт 2 ээлжээр тасралтгүй ажиллах
7	Ажиллах цаг /сард/	600 мото/цагаас доошгүй
8	Тээврийн зардал	Гүйцэтгэгч тал хариуцна.
9	Ажлын үнэлгээ	Цаг ашиглалт, бусад тооцоолол
10	Гүйцэтгэх ажил	<ul style="list-style-type: none"> <li>• Уурхайн карьераас нүүрс олборлож машин ачилт хийж гүйцэтгэх.</li> <li>• Завсрын хөрс хуулалтанд ажилт хийх.</li> <li>• Инженерийн бусад ажиллуудыг хийх.</li> <li>• Ус шүүрүүлэхийн шинэ D шугамын төв болон салбар шугамуудын далангийн хэлбэржүүлэлт, шидэлт хийх.</li> </ul>
11	Түрээслэх нөхцөл	<ol style="list-style-type: none"> <li>1. Ээлжиндээ 12 цагаар ажиллах буюу 3-аас доошгүй ээлжийн оператортой байх.</li> <li>2. Дээр дурьдсан хүчин чадлын үзүүлэлтийг бүрэн хангах.</li> <li>3. ХАБЭА-н стандарт шаардлагыг хангасан техник, хувцас хэрэгсэлтэй байх.</li> <li>4. Хариуцсан нэгж ажилтантай байх.</li> </ol>
12	Аж ахуй нэгж байгууллага	Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болон хувь хүн байна.
13	Онцгой нөхцөл:	<ul style="list-style-type: none"> <li>- Уурхайн дотоод, дүрэм журмын дагуу ажиллах</li> <li>- Уурхайн нутагт дэвсгэрт ус зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг ажилд холбогдох хүмүүсийн заавраар ажил гүйцэтгэх.</li> <li>- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ тооцож ажиллах.</li> <li>- Ажлын даалгавар наряд заавал авч ажил гүйцэтгэх</li> <li>- Уурхайн нутагт дэвсгэрт ажилчдын амрах байр сууцыг байрлуулж болох ба эсвэл уурхайн ажилчдын тосгоноос ажилдаа ирэх буцах автобусаар үйлчлүүлэх боломжтой.</li> </ul>

---

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(**“Шивээ Овоо” ХК**)-ийн гүйцэтгэх захирал Ц. Энхтүвшин танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| 2. Төслийн менежерийн шийдвэр                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| 4. Аюулгүй байдал                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| 5. Зааварчилгаа                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| 6. Маргааныг шийдвэрлэх                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>             |   |
| 7. Ажлын хөтөлбөр                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежер хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежер хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| 9. Зөрчил, гологдол арилгах                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>2</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |

<sup>2</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

11. Үе шатны ажлын хуваарь
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. Алданги
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>3</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

14. Ажил дуусгах
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

---

<sup>3</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.



---

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан

---

материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх (ГЕН – 1)</b>       | 1.1. Гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод заагдсан ажлыг хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр (ГЕН – 3)</b> | 2.1. “Шивээ Овоо” ХК-ийн үйлдвэрлэлийн талбайд 1 сарын хугацаагаар ажил гүйцэтгэнэ.  |
| <b>3. Аюулгүй байдал (ГЕН-4)</b>                    | <p>5.1. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>5.2. Ажил гүйцэтгэгчийн томилсон ажилтан нь компанийн ХАБЭА-н журмыг бүрэн мөрдөж ажиллана.</p> <p>5.3. Ажил гүйцэтгэгч нь өөрийн ажиллуулж буй ажилтныг ХАБЭА-н хувцас, хамгаалалтын хэрэгслээр бүрэн хангасан байна.</p> <p>5.4. Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт болон, дүрэм, журам нормуудыг чандлан мөрдөж ажиллах.</p> <p>5.5. Ажил гүйцэтгэх хугацааны ХАБЭА-тай холбоотой асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.</p> <p>5.6. Ажил гүйцэтгэгч талын ажилтнууд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд ажил гүйцэтгэгч тал нь ХАБЭА-н тухай хуулийн 29.1-д заагдсан арга хэмжээг шуурхай авах бөгөөд харьяа нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нарт мэдээлэх, 29.2-т заасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс томилж судлан бүртгэх үүргийг хүлээнэ. Ингэхдээ Монгол улсын Засгийн газрын 2015 оны 269-р тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг мөрдөж ажиллах үүрийг хүлээнэ.</p> |
| <b>4. Эцсийн тооцоо (ГЕН – 16)</b>                  | 7.1. Гэрээний төлбөрийг Технологи бодлогын хэлтэс, техник ашиглалтын албаны гаргасан тодорхойлолтыг үндэслэн 30-45 хоногийн дотор шилжүүлнэ.   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>4</sup></b>  | <p>9.1. Алданги оногдуулах хувь: [ 0 ]</p> <p>Алдангийн нийт дүн: [ 0 ]</p>  |

<sup>4</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>5</sup>

БАТЛАВ  
“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

БАТЛАВ  
“.....” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ЭНХТҮВШИН

/...../

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2019 оны .. дугаар сарын ..... өдөр

№

Сэвхүүл

Энэхүү гэрээг нэг талаас Говьсүмбэр аймаг Шивээговь суманд байрлах, 2004879 регистрийн дугаартай “Шивээ-Овоо” ХК (цаашид “захиалагч”) түүнийг төлөөлж Технологи бодлогын хэлтсийн дарга П.Цэндпүрэв нөгөө талаас .....хот, ..... дүүрэг, ..... хороо, ..... тоотод байрлах, ..... регистрийн дугаартай “.....” ХХК (цаашид “Ажил гүйцэтгэгч”), түүнийг төлөөлж ..... (цаашид хамтад нь “Талууд” гэх), нар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 33.1, 33.2 дугаар зүйл, Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг үндэслэн дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.

#### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр ажил гүйцэтгэгч нь өөрийн өмчлөлийн .....маркийн гидроэкскаватор (цаашид “Техник хэрэгсэл” гэх)-аар Уурхайн талбайд 30 хоногийн хугацаанд даалгасан ажлыг гүйцэтгэж захиалагч нь ажил гүйцэтгэгчид хийсэн ажлын хөлсийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээгээр нарийвчлан зохицуулаагүй харилцааг Монгол улсын иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3. Талуудыг төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар гэрээг байгуулагдсанд тооцож хугацааг тоолох ба гэрээгээр хүлээсэн үүргээ харилцан биелүүлснээр гэрээг дуусгавар болсонд тооцно.

1.4. Техникийг ажиллуулахдаа ээлжийн ажилтныг 3 ээлжээр зохион байгуулах ба өдөрт 20 мот/цагаар ажиллана.

1.5. Гэрээг 2 хувь үйлдэх ба хуулийн ижил хүчинтэй.

#### Хоёр.Хөлс тооцох болон төлбөр хийх журам, хугацаа

2.1. Гэрээний нийт үнэ ..... /үсгээр/ төгрөг болно. НӨАТ-тай дүн болно.

2.2. Энэхүү ажлын хөлсөнд ээлжийн операторуудын ажлын хөлс, даатгал хураамжийн төлбөр гэрээний үнэд орсон болно.

2.3. Захиалагч нь урьдчилгаа төлбөр төлөхгүй болно.

2.4. Захиалагч нь төлбөрийг гэрээ дүгнэж акт үйлдсэнээс хойш хуанлийн 30-45 хоногийн дотор шилжүүлнэ.

#### Гурав.Захиалагчийн эрх үүрэг

3.1. Ажил гүйцэтгэгч нь техник хэрэгслийг захиалагчаас өгсөн зааврын дагуу ашиглах бөгөөд удирдлагаар хангана.

3.2. Ажил гүйцэтгэсэн төлбөрийг гэрээний 2.4-т заасан хугацаанд төлж барагдуулна.

<sup>5</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

3.3. Захиалагч нь тоног төхөөрөмжийг ажиллах ажлаар бүрэн хангаж сул зогсолт гаргахгүй байхаар зохион байгуулна.

3.4. Захиалагч нь техник хэрэгсэлд аливаа эвдрэл гэмтэл, осол гарсан тохиолдолд ажил гүйцэтгэгчид 24 цагийн дотор мэдэгдэнэ. Ажил гүйцэтгэгчийн эрх бүхий төлөөлөгчид ирж осол гэмтлийн шалтгааныг тогтоон Тоног төхөөрөмжийг уг ослын газраас хөдөлгөхгүй байлгана.

3.5. Захиалагч нь ажил гүйцэтгэгчийн томилсон ажилтнуудад компанийн ХАБЭА-н журам болон аюулгүй ажиллагааны талаар сургалт явуулна.

3.6. Захиалагч нь техник хэрэгслийг ажиллуулахад шаардлагатай зарцуулсан дизель түлшний зардлыг бүрэн хариуцна.

### **Дөрөв. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

4.1. Ажил гүйцэтгэгч нь захиалагчаас техник хэрэгслийн байдал, ашиглаж буй нөхцөл, түүнийг ажиллуулж буй цаг, ачааллын байдалтай газар дээр нь танилцах эрхтэй.

4.2. Ажил гүйцэтгэгч нь техник хэрэгслийг ажиллуулахад шаардлагатай 3 ээлжийн оператор томилон ажиллуулна.

4.3. Техник хэрэгсэл захиалагчийн ашиглалтын буруугаас шалтгаалахгүйгээр ажиллахгүй бол ажил гүйцэтгэгч нь аль болох богино хугацаанд түүнийг засварлан, хэвийн ажиллагаатай болгоно. Техник хэрэгсэл ажиллахгүй болсныг хоёр талын хамтарсан актаар тогтооно.

4.4. Ажил гүйцэтгэгч нь ашиглах болон хадгалах журам зөрчсөнөөс бусад шалтгаанаар ажиллахгүй болсон үеийн сул зогсолтын хугацааг ажил гүйцэтгэх хугацаанд оруулахгүй бөгөөд энэ хугацаагаар ажил гүйцэтгэх хугацааг сунгаж болно.

4.5. Ажил гүйцэтгэгчийн томилсон ажилтан нь захиалагчийн эрх бүхий албан тушаалтны шаардлагыг бүрэн биелүүлж, ажлын цаг ашиглалтыг бүрэн хангах үүрэгтэй.

4.6. Ажил гүйцэтгэгч нь техник хэрэгсэлд үйлчилгээг өөрийн зардлаар хийнэ.

4.7. Ажил гүйцэтгэгчийн ажилтан өөрөө ашиглалтын болон тээвэрлэлтийн буруугаас үүдэн гарсан аливаа төлбөрийг ажил гүйцэтгэгч хариуцна.

4.8. Захиалагч нь техник хэрэгслийн ашиглалтын болон ажил гүйцэтгэгчийн эрх ашгийг ноцтойгоор зөрчиж буй, эсвэл зөрчих өндөр магадлалтай гэдгийг эрх бүхий этгээд акт үйлдэн тогтоосон үед ажил гүйцэтгэгч тоног төхөөрөмжийг зогсоон өөрийн байранд авч ирэх эрхтэй.

4.9. Ажил гүйцэтгэгчийн томилсон ажилтан нь компанийн ХАБЭА-н журмыг бүрэн мөрдөж ажиллана. Ажил гүйцэтгэгч нь өөрийн ажиллуулж буй ажилтныг ХАБЭА-н хувцас, хамгаалалтын хэрэгслээр бүрэн хангасан байна.

4.10. Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт болон, дүрэм, журам нормуудыг чандлан мөрдөж ажиллах. Ажил гүйцэтгэх хугацааны ХАБЭА-тай холбоотой асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

4.11. Ажил гүйцэтгэгч талын ажилтнууд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд ажил гүйцэтгэгч тал нь ХАБЭА-н тухай хуулийн 29.1-д заагдсан арга хэмжээг шуурхай авах бөгөөд харьяа нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нарт мэдээлэх, 29.2-т заасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс томилж судлан бүртгэх үүргийг хүлээнэ. Ингэхдээ Монгол улсын Засгийн газрын 2015 оны 269-р тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг мөрдөж ажиллах үүрийг хүлээнэ.

### **Тав. Давагдашгүй хүчин зүйл**

5.1. Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын тав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1. Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнийг цуцлах

7.1. Гэрээнд зөвхөн талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулна. Гэрээний хугацааг сунгах, өөрчлөх болон цуцлах саналыг нөгөө талдаа 3 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Гэрээг цуцлах талаар аль нэгэн тал албан ёсоор бичгээр мэдэгдэл гаргаагүй тохиолдолд гэрээ хүчинтэй хэвээр үлдэнэ.

### Найм. Бусад нөхцөл

8.1. Энэ гэрээг монгол хэл дээр хоёр эх хувь үйлдэх бөгөөд Талууд нэг нэг хувийг хадгална.

8.2. Нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрийн эрх үүргийг гуравдагч этгээдэд аль нэг тал шилжүүлэх эрхгүй.

8.3. Захиалагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, өмчлөгч, үүсгэн байгуулагчид өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ хүчин төгөлдөр байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

### ЗАХИАЛАГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:

\_\_\_\_\_ С. Ариунзул  
Санхүү эдийн засаг, хангамжийн  
хэлтсийн дарга  
\_\_\_\_\_ П.Цэндпүрэв  
Технологи бодлогын хэлтсийн дарга  
\_\_\_\_\_ Н.Энхжаргал  
НББА-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч  
\_\_\_\_\_ Э.Мандахнаран  
Хуулийн зөвлөх  
Хаяг: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум  
42020 Сэвхүүл  
Утас: (976)-7054-6464  
Факс: (976)-7054-6363

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

\_\_\_\_\_ /...../  
Албан тушаал  
Хаяг: .....  
Утас: .....